

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамъяндорж	Дугаар	L266
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Дэлгэрхаан сум
Төрсөн газар	Дэлгэрхаан сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөрнастан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Норовчойнпэллин хийд	Сүм хийдийн дугаар	ТӨДХ 005
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны10-рсарын 18	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Норовчойнпэллин хийд

Д.Мөнхбат:За тэхээр Жамъяндорж гуай та 1920 онд төрсөн гэж байгаа тиймээ ардын засагтай чацуу

Жамьяан дорж: Аан ? Тийм юм байхаа.

Мөнхбат: Одоо 87 той ?

Жамъяндорж: Аа тийм тийм

Мөнхбат: Энэ Мишиг гүний хошууны энэ Норовчойнпэллин хийд маань одоо таныг бага залуу байхад хичнээн сүм дугантай ямар ямар шашны зан үйл явуулдаг хүрээ хийд хурал номын газар байсан юм болоо ?

Жамъяндорж: Энэ ч яахавдээ хүү минь зун болохлоор цам мам гарч байсан өвөл болохлоор хангал хурна гээд өвлийн хурал хүрж байсан хамгийн сүүлд нь сэмчингийн хурал жанагаггадаг хийгээд тэгээд тардаг аа тэгээд зундаа хайлангийн хурал хурдаг лам нар ирдэг зуны ганжуур манжуур хурдаг тийм л газар байсан

Мөнхбат: Дуганууд ямар ямар дуган дацангууд байсан юм бэ ?

Жамъяндорж: Аа ах нь ч буруу ярих байх. Ухаан нь Цогчин дуган гэж нэг их том дуган байсан юм , сахиусан дуган гэж байсан, ламиран дуган гэж нэг дуган байсан , өвгөн дуган гэж байсан , чойрын дуган гэж байсан, майдар дуган гэж байсан, гүнрэг дуган гэж байсан, ламиран гэж би хэллүү аа хэлсэн ёгын дуган, мамбын дуган, за өөр юу билээ

Мөнхбат: Жүд , зурхайн гэж байсануу?

Жамъяндорж: Жүдийн дуган гэж байсан юм байна за тэгээд жас гэж хоёр талд нь 2 жаахан дуган байсан хурал хурдаг тэрүүнтэйгээ 15 дуган болж байгаа юм. За ийм байна.

Мөнхбат: Тэхээр Норовчоймбиллон хийдийн маань гол шүтээн сахиус ямар бурхан сахиус байсан юм бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жамъяндорж: Манай энэний сахиус жаахан Гомбо гэж сахиус байсан юм. За тэрүүнийг л их шүтдэг юм. За тэгээд сүүлийн үеийн нь бурхан багш богд лам гэгчийг авчирч залсан юм. Тэр нь одоо байдаг юм. За тэгээд энэ Лхам сахиус ч гэж ярьдаг, Жамсран сахиус ч гэж байдаг. Янз бүрийн л байдаг. Дээхэн үеийнх бол цэдэр Гомбо байж.

Мөнхбат: Тэгэхээр одоо энэ таныг бага залуу байх үед энэ Норовчоймболлин хийд шашин номынхоо ид мандан бадралын үед хичнээн лам хуврагтай байсан юм бол оо?

Жамъяндорж: За тэгийг бол ах нь сайн мэдэхгүй юм. Тэгэхээр 600 гаруй ламын данстай байсан гэж би хэлэх гэж байгаа юм.

Мөнхбат: Мундаг том хүрээ байж. Хамгийн сүүлийн хамба нь ямар хүн байсан юм бол, та сонсож мэдсэн байна уу?

Жамъяндорж: Лам нар баригдаад явах үеийн хамбыг ярьж байна уу?

Мөнхбат: Тийм, сүүлчийн хамба?

Жамъяндорж: Сүүлчийн хамба бол ийм юм байгаа юм аа. Цуудайгийн Цэрэндорж гэж хүн байсан юм.

Мөнхбат: Шашны ямар цол мяндагтай хүн байсан юм бол?

Жамъяндорж: За одоо гавж л байдаг байх. Аа ловон лам нь бол Ишмамба гэж хүн байсан. Миний багш. Хамгийн сүүлд энэ урд Норовтын хошуун дээр эм ялгаж байгаад Сэргийдорж гэдэг хүнтэй хамт явсан.

Мөнхбат: Монголын буддын шашны том хүрээ, хийдүүд дэргэдээ гавжийн дамжаа барьдаг энэ тэр гээд дамжаа барьдаг байсан байгаа юм. Тэгэхээр энд ямар ямар дамжаа барьдаг байсан юм бол?

Жамъяндорж: Гавжийн дамжаа гээд л барьдаг байсан юм. Улс амьтныг цуглуулаад, тэгээд тэр хүн гавж л болдог байсан юм. Тэр нь бол яахав айраг боов хийгээд л олон түмэн хишиг энэ тэр хайрладаг л байсан, тэгээд гавж болдог л байсан. Аа тэрийг зүгээр ямар учиртайг нь өвгөн нь мэдэхгүй. Эх болсон 6 зүйл, хамаг амьтны тусын тулд буян үйлддэг. Аа гэгээрэх юм бол дээшээ эрдэм номонд шамддаг тийм л байдаг байх. Тэгэхээр зүгээр гэлэн гэцэл гэвэл жаахан доохнуур л байгаа байх. Аа гавж, аграмба гэхээрээ томордог байх. Одоогоор бол сургууль төгсөөд ирж байгаа хүүхдэд цол өгөхтэй л адил юм даа, тийм ээ.

Мөнхбат: Тэгэхээр энэ Нормчоймбиллон хийд маань хүрээ хийдийн жас сангийн хувьд хэр чинээлэг жастай байсан юм бол? Сан хөгрөнгийг хувьд?

Жамъяндорж: Жас болвол одоо овоо юм уу гэж бодож байгаа юм, би. Цогчин жас гэж байсан. Одоо ганц байшин л үлдэж. Цогчин жас бол яахав улс амьтан тусалдаг, 5, 6 суурь адуутай. Хэдэн суурь хоньтой. Хоёр суурь тэмээтэй ингэж байсан. Энийг бол би сайн мэднэ. Тэр яасан юм гэхээр, баригдаад дуусах үед тэгээд хураалганд ч явсан.

Мөнхбат: Тухайн үеийн хошуу нутгийн хүрээ хийдүүд бас хөрш зэргэлдээ хүрээ хийдүүдтэйгээ ном чадлаараа өрсөлддөг, бурхны шашнаараа ном хаялцдаг тийм дэг жаяг байсан байгаа юм аа.

Жамъяндорж: Ном хаяна гэж байдаг юм байна. Баруун хүрээнээс бол манайд лам нар ирж байсан. Гэхдээ ямар лам ирж тийм ном хаяж байсан гэдгийг бол Жамъяндорж мэдэхгүй. Номгүй лам хаяанд суудаг, малгүй хүрээнд тэнцдэг гэж хуучны үг. Аа би бол зүгээр хаяаны лам. Гэхдээ сайн улсын дэргэд бол их л байсан. Аа тэгж ном

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хаялцдаг улсууд байдаг л юм. Аа тэгээд өвлийн хурал болохоор хурлын сүүлээр ном хаядаг юм байна. Юу ч хаяж байгаа юм бүү мэд. Тэр хаяанд л би багачуултай ноцолдоод зогсож байгаа юм.

Мөнхбат: Энэ хүрээ хийдүүдээс хошуу хүрээндээ бахархал болсон шашны номд нэвтэрсэн эрдэмтэй лам нар цөөнгүй гаржээ. Тэгэхээр энэ яг одоо Мишиг гүний хүрээнээс гарсан том том чадалтай лам нарыг нэрлэвэл таны санаанд одоо ямар ямар хүмүүс байна, таны багшаас эхлээд л?

Жамъяндорж: Мэдэхгүй ээ, манай энд одоо Дооромбо багш гэж нэг хүн байсан. Тэр бол баруун газар хавьд сургууль төгсөж ирсэн юм гэнэ лээ. Тэр бол нэлээн сайн лам байсан. Бас тэр хойно аграмба багш гэж нэг хүн байсан. Тэр бол эмчийн талаар нэлээн явж, бас л хойно сургууль төгссөн юм гэнэ лээ гэж дамын яриа байдаг. Тэр улсын тэнд тэгж ирж байхыг нь би сайн мэдэхгүй. Манай энд бол дээд талаараа ном эрдэм хамгаалсан хүмүүс байсан л байх. Санжаадорж гэж ч нэг санй хүн байсан юм. Чойжилсүрэн гэж нэг сайн хүн байсан юм. Хамгийн түрүүний 7 ламд, 4, 5 сайхан эрдэмтэн орчихсон байх аа. За ийм байна.

Мөнхбат: Сүм хийдийг буулгаж нурааж эхлэсэн тэр 1937, 1938 оны үе байна, тийм ээ. Та 17, 18 настай байсан юм уу даа. Тэгэхээр тэр үеийг эргээд дурсвал таны санаанд ямар юм байх юм. Эхлээд хүрээ хийдийг нь хаачихаад лам нарыг нь бариад явсан юм уу, лам нарыг нь баригдсаны дараа хүрээ хийд цоожтой, эзгүй үлдсэн юм уу. Тэр талаар та дурсвал ямар юм байна?

Жамъяндорж: Энэ болвол манай хүрээ лам нар явчихсан. Энд бол наанаас нь 2 орос, 4 монгол ирсэн байгаа юм. Хоёр асартаа хаалгатай юм, тэр хоёрыг нь иүгжчихээд, урд талынхыг нь хаачихаад тэгээд дотор нь юу болгож байдаг юм. Бид нар бол очих юм байхгүй. Очихоосоо айна шүү дээ. Тэгэхээр тэр дээхэн үед лам нарыг бариад явах үед хүн ямар ч байсан онгируодуу юм байдаг. Ар гэрийг нь бол тиймэрхүү л байсан. Тэгэхээр энүүнийг нураасан улсыг би танихгүй, ибд нарт мэдэтгээгүй. Энэ баруун хойно Номгоны ам гээд нэг хонхор байгаа юм. За тэнд бурхан шашныг нь шатаадаг ч юм уу, хаядаг ч юм уу, булдаг ч юм уу. Тийм болгоод ингэсэн байх аа. Эндээс машинаар ачаад явахыг нь үзээгүй шүү, тэр сураг тийм байна.

Мөнхбат: Тэр хэлмэгдүүлэлтийн цэвүүн цагт одоо энэ Норовчоймболлин хүрээнд байсан 600 гаруй лам нарын хэд нь баригдаж явсан байдаг юм бол...?

Жамъяндорж: Хэд нь баригдаж явсныг бол ах нь тоог нь мэдэхгүй.

Мөнхбат: Баримжаагаар?

Жамъяндорж: Ерөөсөө дээд зэргийн томчуудыг л хамаад барьчихсан.

Мөнхбат: Тэндээс нутаг усандаа амьд сэрүүн ирсэн хүн бий юу?

Жамъяндорж: Нутагтаа ирсэн хүн 2 бий.

Мөнхбат: Бусад нь бол сураггүй?

Жамъяндорж: Илдэнгийн Ламдорж гэж их том лам байсан. Их ч эрдэмтэй хүн байсан. Тэр ирсэн. Цогчин унзад байсан Хуушишдорж гэдэг хүн ирсэн. Энэ 2 л ирсэн. Самдандорж гэдэг гэлэн хүн ирсэн. За энэ 3 л ирсэн, бусад нь бол сураггүй ээ. Манай их унзад байсан Норовцэрэн гэдэг хүний дүү чавганц нь манай ах гэлэн Халхын голд тэмээтэй хонь хариулж байна гэж нэг дуулдсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: За ингээд том лам нарыг нь барьж хэлмэгдүүлж, бага лам нарыг нь хөдөө хүчээр гаргаж хар болгожээ. Сүм хийд эзгүйрлээ. Тэгэхээр тэр 15, 16 дуган гэж байсан. Тэр 15, 16 дуганыг нэг цогчин дуганыг нь үлдээгээд бусдыг нь шатаачихсан юм болов уу...?

Жамъяндорж: Дуганууд бол энэ дээр үлдсэн. Ингэхээр маршал Чойбалсан гэдэг хүн Зүүн Жанжидын сургууль байж байхад 7 цэрэгтэй манай энүүгээр ирсэн юм аа.

Мөнхбат: Хэдэн оны үе бол?

Жамъяндорж: Аа гучин оны үе байх аа, хорин найм, есөн оны үе. Тэгэхээр дуганыг бол танай сургууль авч сайхан барилга бариарай гэж байхыг би өөрөө дуулсан. За тэгээд энийг чинь нураагаад яахав дээ, гээд сургуулийн гал тогоонд өгсөн юм гээд зарцуулчихсан юм даа. Тэгээд бусад нь тэгс ингэс хийгээд алга болсон. Тэр тэрийг авч явсан гэж хэлэх юм байхгүй. Майдрын дуганы ганц хонх дуганы ард байдаг юм. Тэр л үлдсэн байх даа. Бурхан хийдэг хонх нь дуганаасаа тусгай. Тийм л байна.

Өсөхбаяр: Зодын лам нар байсан уу, лүйжин тавьдаг?

Жамъяндорж: Өө тэр лүйжин лам нар чинь хэд ч байсан юм.

Өсөхбаяр: Тусгай дугантай байсан уу?

Жамъяндорж: Зочийн дуган гэж би дуулаагүй. Дуган байгаагүй. Зүгээр гадуур зоч тавьдаг улсууд зөндөө л байсан. Энд болвол ингээд зоч нар цуглаад лүйжин тавьдаг юм гэсэн газар ах нь үзээгүй, тавиулж ч байгаагүй байх.

Өсөхбаяр: Зун цам харайдаг байсан гэсэн ш дээ, цам чинь хэдэн багтай ямар цам гардаг байсан юм бол?

Жамъяндорж: Тэр бол юу, ах нь бол тоолоогүй. 100 шахуу цам гардаг байсан байх. Дамдин чойжоо энэ тэрийнх бол тусгай, тийм ээ. Дамдин чойжоогийн багархуу багтай цам хааяа зурагтаар гарч бай юм, тийм ээ.

Өсөхбаяр: Тэгвэл 100 орчим багтай байсан гэхээр 108 багтай жажор цам гээд байдаг ш дээ.

Жамъяндорж: Аан?

Өсөхбаяр: 108 багтай жажор цам гээд байдаг ш дээ.

Жамъяндорж: Тэгэхээр энэ юу юм л даа. Эхний өдөр бол наанчим гээд цам гардаг байсан. Тэгээд л олон цам гарна. Шар өвгөн, хөх өвгөн гээд л хоёр өвгөн байдаг. Маргааш нь майдрын тахилын цам гээд баахан цам гардаг. Хашин хаан ч гээд нэг зогсож байдаг. Мам ч гээд нэг салгаад хаячихсан гээгтэй хэдэн хар хувцастай юм зогсож байдаг.

Өсөхбаяр: Тэр дуганд тусдаа харайдаг цам байсан уу, ганцхан хүн?

Жамъяндорж: Үгүй ээ. Дуганаас бол Дамдин чойжоо л их урилгатай, удаж гарч ирдэг. Тэр дотор нь цам харайдаг байсан уу гэж байгаа юм уу?

Өсөхбаяр: Тийм, тэр олон хүн суучихаад л ганцхан хүн харайдаг?

Жамъяндорж: Аа олон хүн үүдэнд суулгаад л 3 давхар асартай юм, их дуган. Тэрний хамгийн нүүрэнд билүү урдаар гарч ирдэг. Тэгээд л тэрүүгээр харайгаад л гадуур дэглээд л, буцаж орох нь ороод л. Яг сор зална гэхээр баруун урагшаа явдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өсөхбаяр: Яг цамаа харайчихаад л сороо залдаг байсан уу?

Жамъяндорж: Тийм, тэгээд зайдангууд гэж ярьдаг, харчууд цаасан цэнэгтэй бүү энэ тэр дуугаргадаг тийм байсан юм.

Өсөхбаяр: Цам тэгээд хэдэн өдөр харайдаг байсан юм?

Жамъяндорж: 2 өдөр.Тэгээд маргааш нь майдар эргэнэ.

Өсөхбаяр: Чойрын дугантай байсан гэсэн, тэгэхээр сэр исчаа ч гэж байдаг, гүнчин исчаа ч гэж байдаг. Ямар исчаатай байсан юм бол?

Жамъяндорж: Аа мэдэхгүй, ямар юмаа?

Өсөхбаяр: Чойрын исчаа гээд гол одоо номлолоо дагадаг.Аль ламын номыг дагадаг тийм исчаатай байсан бэ гэж?

Жамъяндорж: За би сайн дуулах ч үгүй юм.

Мөнхбат: За ганц ингээд цогчин дуган үлдсэн гэж байгаа, тийм ээ?

Жамъяндорж: Үгүй, сахиусны дуган.

Мөнхбат: Тэгвэл сахиусны дуганаас бусад тэр дуганууд хэдэн оныг хүртэл байсан юм бол, энэ дөч тавин нэгдэл нийгмийн нүүрийг үзсэн юм болов уу?

Жамъяндорж: Аа тэр бараг үзээгүй байх.Хоёр жатган нь үзсэн байх, яаж байна гэхээр тэрүүнд чинь гуанз хийж байсан юм.Тэр хоёр жатганы ухаан бол өргөлийн мал уядаг чулуу ч зоолттой байдаг.Яахав майдар эргээд тэр хамгийн хойно том нэг суварга байсан.Тэрний сүүлд нэг буурь нь байж байсан байгаа юм.

Мөнхбат: За таньд зохих мэдээлэл өгсөнд баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл манай судалгааны ажлын багт үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Та урт насалж удаан жаргаарай гэж хүсье.

Жамъяндорж: За яахав ах нь мэдэх юм аа л хэллээ. Одоо нэмэх юм ч алга, санах ч юм алга.

Мөнхбат: За энд нэг зүйлийг тайлбарлан хэлэхэд хорин намй, хорин есөн оны үед гэж Жамъяндорж гуайн хэлээд байгаа Богд хаант монгол улсын , олноо өргөгдсөн монгол улсын он тооллоор гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хорин найм, хорин есөн он гэдэг бол одоогоор 1938, 1939 он гэж ойлгож болно.